

Хүүхдэд зориулсан Библи танилцуулж байна

Мэхлэгч
Иаков



Зохиогч: Edward Hughes

Зураглаач: M. Maillot; Lazarus

Найруулсан: M. Kerr; Sarah S.

Орчуулсан: Damdin Norolsuren

Бүтээсэн: Bible for Children

www.M1914.org

©2014 Bible for Children, Inc.

**Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах
эрхтэй харин худалдахыг хориглоно.**



**Бурхан танай гэр бүлийг
хүүхдээр ивээж байсан
уу? Ямар гайхалтай
вэ? Исаак Ребека
хоёрыг ч илүү баяр
хөөрөөр ерөөсөн юм.
Бурхан тэдэнд ихэр
хөвгүүдийг өгчээ.**



Хөвгүүд эхийн
хэвлийд байхаасаа
тэмцэлджээ.
Ээж нь
Бурханд
залбирахад
Бурхан хөвгүүд
чинь хоёулаа
хоёр өөр улсыг
удирдах ба бага
нь агуу нэгэн болно
гэв. Уг нь ууган
илүү байдаг. Эцэст
нь хөвгүүд төржээ.



Хөвгүүд хоорондоо адилгүй байв. Том хүү Есав нь үсэрхэг арьстай бөгөөд гарамгай анчин болов. Иаков нь гөлгөр арьстай бөгөөд майхандаа суудаг байлаа. Эцэг нь Есавдаа хайртай харин Ребека Иаковтаа хайртай байв.



Нэгэн өдөр, Есав ихэд өлсөж ядарсаар гэртээ иржээ.
"Надад идэх юм өгөөч" гэж Иаковоос асуув. Иаков
"Надад ууган хүүгийн эрхээ оронд нь өг" гэв. Есав

ингэж Бурхны
ууган хүүгийн
амлалтыг үл
тоомсорлов.
Тэр ингэж ууган
хүүгийн эрхээ
Иаковт худалдав.
Одоо Иаков
эцгийнхээ дараа
гэр бүлээ толгойлох
эрхтэй болов.



Нэг шөнө Бурхан Исаактай ярьжээ. "Би бол чиний эцэг Абрахамын Бурхан. Би чамтай хамт байна.

Би чиний хойч үеийг ерөөх болно." гэжээ.

Исаак Бурханд мөргөдөг байсан ч түүний хүү Есав Бурхныг мэддэггүй ард түмэн

хитчүүдээс хоёр

эхнэр

авчээ.




Исаак өтөлжээ. "Надад шинэхэн ангийн мах авчраач" гэж Есавд хэлэв. "Тэгээд би чамайг ерөөе" гэв. Эцэг нь ууган хүүгээ онцгойлон ерөөдөг байв. Есав ан хийхээр яаран одов. Ребека үүнийг сонсжээ. Тэр ууган хүүгийн ерөөлийг Иаков аваасай гэж хүсэв.



Ребекад нэгэн санаа
төржээ. Тэрээр
Исаакийн дуртай
хоолыг хийгээд,
Иаковт Есавын
хувцсыг өмсүүлэн гар
хүзүүг нь ишигний
арьсаар ороожээ.
Исаакын хараа
муудсан тул сайн
хардаггүй байжээ.
Тиймээс тэд түүнийг
мэхэлжээ.



Иаков Исаакт хоол авч
ирэв. Исаак "Чиний
дуу чинь Иаковынхтай
адил боловч чиний гар
Есавтай адил үстэй юм"
гэв. Тэр өгсөн хоолыг
нь идэж дуусаад Исаак
өмнөө байгаа хүүгээ
ерөөжээ.



Иаковыг гарсны дараахан
Есав Исаакруу ирэв. "Энэ
танд зориулсан хоол" гэхэд
Исаак өөрийг нь мэхэлснийг
мэдэв. "Исаак Би ерөөлөө
буцааж авч чадахгүй
энэ нь боломжгүй"
гэв. Есавын зүрх
өшөө хорслоор
дүүрчээ. Тэр дүү
Иаковаа алахаар
шийджээ.




Ребека Есавын уурласныг сонсжээ. Тэр Иаковт "Авга ахынхаа гэр уруу яв" гэжээ. Исаак Иаковыг эхийнхээ гэр бүлийнхнээс эхнэр хайхаар явахыг зөвшөөрөв. Ингээд Иаков гэрээ орхин гарав.




**Тэр шөнө Иаков
түр зогсон чулуу
дэрлэн унтжээ.
Магадгүй тэр
ганцаараа явсан
болоод айсан
ч байж
магад.**



Гэвч тэр
ганцаараа биш
байв. Бурхан
түүнтэй
зүүдэнд нь
ярьжээ.





**"БИ БОЛ ЧИНИЙ ЭЦГИЙН БУРХАН
АБРАХАМ ИСААКИЙН БУРХАН БАЙНА.
БИ ЧАМТАЙ ХАМТ БАЙНА. БИ ЧАМД ЭНЭ
ГАЗРЫГ ӨГӨХ БОЛНО. ЧИНИЙ ГЭР
БҮЛЭЭР ЭНЭ ДЭЛХИЙН БҮХ ГЭР
БҮЛҮҮД ЕРӨӨГДӨХ БОЛНО" ГЭВ.**




A stylized illustration of a sky scene. In the upper left, a small yellow sun with radiating lines is partially obscured by a white cloud. In the center, a larger yellow sun with radiating lines is also partially obscured by a white cloud. To the right, a yellow crescent moon is visible, with a blue arc representing a rainbow behind it. The entire scene is set against a white background with a black outline, suggesting a thought bubble or a frame.

**Бурхан түүнтэй ярсны
дараа тэр сэрэв. Тэр ихэд
айсан байв.**



Иаковын авга ах Лабан
түүнийг угтан хүлээж авав.
Иаков авга ахынхаа охин
Рахелд хайртай болж
түүнтэй гэрлэхийн



тулд авга ах
Лабандаа долоон
жил үйлчилжээ.

Харин хурим
хийсэн шөнө Лабан
Иаковыг хуурчээ.



"Энэ чинь Леа байна Рахел биш байна" гэж Иаков гомдоллов. "Та намайг хуурсан байна" гэхэд Лабан "Том охин маань эхэлж хурим хийх ёстой" гэв.



"Одоо Рахелтай хурим хийхийн тулд дахин долоон жил надад үйлчил" гэв. Иаков зөвшөөрөв. Магадгүй тэр өөрөө аав Исаак болон ах Есавыг хэрхэн хуурч байснаа санаа биз ээ.



**Нэгэн өдөр Бурхан түүнд
буцаж яв гэж хэлжээ.
Иаков гэр бүл мал сүргээ
цуглуулан төрсөн нутаг
уруугаа буцахаар гарлаа.**



**Маш том аян байв.
Есав Иаковтай
уулзахаар дөрвөн
зуун хүний хамт
угтан ирэв. Тэр
Иаковт муу зүйл
хийсэнгүй.**



**Тэр Иаков уруу гүйн
очоод түүнийг тэврэн
авчээ. Иаков Есав
хоёр энэ үеэс дахин
нөхөрлөсөн бөгөөд
Иаков аюулгүй
гэртээ харьсан юм.**



МЭХЛЭГЧ ИАКОВ

Бурханы үг Библиээс авсан түүх

Эхлэл 25-33

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130



Төгсөв



Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.

Хэрвээ та энэ үнэнд итгэж байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй: Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө амьдрахад туслаач. Амен.

Библи уншиж өдөр бүр Бурхантай ярилцаарай! Иохан 3:16

